

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 9 дүгээр
арын 10-ны өдөр

Дугаар 189

Улаанбаатар хот

“Ремикон” ХК-ийн анхдагч зах
зээлийн арилжааг зогсоох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Ремикон” ХК-ийн нийтэд санал болгон арилжиж байгаа хувьцааны анхдагч зах зээлийн арилжааг 2009 оны 9 дүгээр сарын 18-ны өдрөөр дуусгавар болгон зогсоосугай.

2. Тус компанийн нийтэд санал болгон арилжаалж буй 99 451 361 /Ерэн есөн сая дөрвөн зуун тавин нэгэн мянга гурван зуун жаран нэг/ ширхэг энгийн хувьцаанаас энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан өдрөөр тасалбар болгон зарагдаагүй үлдсэн хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/, хөрөнгийн биржийн бүртгэлээс хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжаас хасахыг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

3. Хорооны 2008 оны 117 дугаар тогтоолын 4 дэх заалтад заасан Х.Ганхуягын нэмж оруулах 1 633 425 250 төгрөгийн хөрөнгө оруулалт буюу 16 334 262 ширхэг энгийн хувьцаатай тэнцэх хэмжээний тоног төхөөрөмжүүдийг компанид бүрэн нийлүүлж дуусгах хугацааг 2009 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөр шинэчлэн тогтоож, дээрх хугацаанд уг хөрөнгө оруулалтыг бүрэн хийж гүйцэтгээгүй тохиолдолд тус компанийн нэр дээр тусгаарлагдсан дээрх 16 334 262 ширхэг энгийн хувьцааны бүртгэлийг хүчингүй болгохыг “Ремикон” ХК /Х.Ганхуяг/-т анхааруулсугай.

4. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан хугацаанаас хойш ажлын 5 хоногт багтааж тус хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэхийг Хорооны дарга /Д.Баярсайхан/-д зөвшөөрсүгэй.

5. Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны тайланг хуульд заасан хугацаанд Хороонд ирүүлэхийг “Ремикон” ХК /Х.Ганхуяг/, “Гаули” ХХК /Ким Сын Квон/-д тус тус үүрэг болгосугай.

6. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН